

Захиалга өгөх, хуваарилалт хийх заавар

Хөрөнгө оруулагч дараах хэлбэрээр захиалга өгч болно

- Өрсөлдөөнт саналд өгөөжөөр, өрсөлдөөнт бус саналд нэрлэсэн үнээр санал өгнө.
- Өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналд хоёуланд нь захиалга оруулах бол захиалга тус бүрээр тусад нь санал ирүүлэх бөгөөд ирүүлсэн захиалгын нийт хэмжээ нь арилжаалахаар зарласан үнэт цааснаас ихгүй байна.
- Өрсөлдөөнт бус саналд нэг хөрөнгө оруулагч хамгийн ихдээ нэг захиалга оруулна
- Өрсөлдөөнт санал буюу өгөөжийн саналыг мянгатын орны нарийвчлалаар ирүүлж болно.

Хуваарилалт

- Өрсөлдөөнт бус саналыг өрсөлдөөнт саналаас түрүүлж хуваарилна.
- Өрсөлдөөнт бус саналд хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн 500 ширхэг хүртэл үнэт цаасыг шууд хуваарилах бөгөөд үлдсэн санал дээр хувь тэнцүүлэх зарчмын дагуу дараах томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ:

$$P = B * \frac{V2}{V1}$$

- P = Тухайн арилжаанд оролцогчид хуваарилах хэмжээ (бутархай орныг бүхэлчилж тооцно)
- $V1$ = Арилжаанд оролцогчдын ирүүлсэн нийт саналын хэмжээ
- $V2$ = Арилжаанд оролцогчийн ирүүлсэн саналын хэмжээ
- B = Хуваарилах үлдэгдэл хэмжээ
- Томъёоны дагуу бүхэлчлэхэд 1 ширхгийн зөрүү үүссэн тохиолдолд хамгийн том захиалга дээр тохируулга хийнэ
- Өрсөлдөөнт бус саналд ирүүлсэн 500 ширхэг хүртлэх саналуудын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилхаар тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд шууд хувь тэнцүүлэх зарчмаар явагдана.
- Өрсөлдөөнт бус саналын өгөөж нь амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж өгөөжтэй тэнцүү байна. Өрсөлдөөнт саналын өгөөж нь тухай хөрөнгө оруулагчаас ирүүлсэн хүүгийн санал байна.
- Өрсөлдөөнт бус саналын нийт хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй бол хуваарилалтыг хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналаар хийнэ.
- Өрсөлдөөнт бус хуваарилалтыг хийсний дараа хөрөнгө оруулагчаас ирүүлсэн өрсөлдөөнт саналыг хүү (өгөөжийн хувь)-ний өсөх дарааллаар жагсаан, хамгийн бага хүүгийн саналаас эхлэн хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн арилжаанд оролцогчийн ирүүлсэн ижил хүүгийн нийт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмын дагуу хуваарилалтыг хийнэ.
- Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их тохиолдолд өрсөлдөөнт саналд хуваарилах хэмжээг арилжаалахаар зарласан хэмжээний 100 хувь хүртэл өсгөж болох бөгөөд ингэхдээ хөрөнгө оруулагчаас ирүүлсэн өрсөлдөөнт саналыг хүү (өгөөжийн хувь)-ний өсөх дарааллаар жагсаан, хамгийн бага хүүгийн саналаас эхлэн хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн арилжаанд оролцогчийн ирүүлсэн ижил хүүгийн нийт саналын хэмжээ хуваарилах боломжит хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмын дагуу хуваарилалтыг хийнэ.

- Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага тохиолдолд өрсөлдөөнт бус саналд хуваарилах хэмжээг арилжаалахаар зарласан хэмжээний 100 хувь хүртэл өсгөж болох бөгөөд ингэхдээ захиалгыг нэрлэсэн үнээр биелүүлж захиалгын хэмжээ хуваарилах боломжит хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмын дагуу хуваарилалтыг хийнэ.
- Купоны хувийг амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж утгаар тогтооно.
- Үнэт цаасны үнийг дараах томъёогоор тооцоолно.

$$P_C = C * \left(\frac{1 - \frac{1}{\left(1 + \frac{i_c}{n}\right)^{\frac{t}{365} * n}}}{\frac{i_c}{n}} \right) + F * \left(\frac{1}{\left(1 + \frac{i_c}{n}\right)^{\frac{t}{365} * n}} \right)$$

- P_C = Үнэ
- F = нэрлэсэн үнэ
- C = купон (Нэрлэсэн үнээс тодорхой хувиар тооцон тогтмол давтамжаар төлөх хүүгийн төлбөр)
- i_c = хөрөнгө оруулагчийн захиалгад оруулсан хүүгийн хувь, хэмжээ
- n = Нэг жилд купон төлөгдөх давтамж
- t = хугацаа (өдрөөр)